

БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАР, ҮЕЧЛЭЛИЙГ ТОГТОЛЦООНЫ ОНОЛЫН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭХ НЭГЭН БОЛОМЖ

Ч.Пүрэвдорж

Abstract

The article has analyzed education developmental generalizations accordance with educational theory and analysis due to the educational components.

As a result of educational development generation the report suggested formal education, non formal education, informal education, based on educational phase components and Mongolian educational phase development will be periodized by the new method.

Three kinds of models which were called traditional, ideological, pragmatic modals connecting with generation, based on education internal factors, were determined in Mongolia.

The main goal of the article is to support biological popular law which biodiversity adapt of natural evaluation is learnt by nomadic herders by just normal living surroundings and it implements due to the informal education.

Key ideas: Alive features of system, Informal education during the human livings, Inseparable features, Periodic time of development system, Education development model, Traditional model, Ideological model, Pragmatic model, Appropriate mixture, Adaption.

Шинжлэх ухааны судалгаанд энгийн шалтгаан дарааллын аргаас судлах зүйлийн бүхэллэг чанар, гарал үүсэл, хувьсал Хөгжлийн явцад тулгуурладаг шинэ хандлага бий болсон байна. Судалгаа, танин мэдэхүйн аргад гарсан энэхүү дэвшлээс үүдэн, шинжлэх ухааны аль ч салбарт хэрэглэж олох тогтолцооны хандлага, тогтолцооны онол, тогтолцооны шинжилгээ үүсэн хөгжжээ. Шинжлэх ухааны аж төрөх ёсонд гарсан онол-арга зүйн өөрчлөлтийг дагаж шинжлэх ухааны сэтгэхүйд ч өөрчлөлт гарсан байна. Бид тогтолцооны шинжилгээг боловсролын салбарт ашиглах цуврал судалгаа явуулж байгаа бөгөөд энэ удаад түүний нэгээхэн үр дүнг эмхлэн мэдээлэхийг хичээв. Аль ч үеийн боловсрол өмнөх хөрс суурин дээрээ хөгждөг зүй тогтол бий. Үүнийг боловсролын залгамж холбоо гэдэг. Албан боловсрол (Formal Education), албан бус боловсрол (Non Formal Education) амьдарч аж төрөх явцад олох

анформал боловсрол (In Formal Education) гэсэн боловсролын гурван төрөл байдаг. Боловсролын эл гурван төрөл хоорондоо харилцан шүтэлцэж, нэгэн бүхэллэг чанарыг үүсгэн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. Улс орны боловсролын тогтолцоог бүхэлд нь сансрын уудам зайд хүн ардыг тээж, зорилго чиглэлтэй урагшилж яваа аварга том “амьтан” хэмээн төсөөлж болох мэт. Амьд бусын хувьд тогтолцоо хэмээх нь тухайн нийлмэл төвөгтэй зүйлийн амьдлаг шинжийг хийсвэрлэн ойлгохыг хэлнэ. Тэрхүү тогтолцоо хэмээгдэх бодит зүйлийн хийсвэрлэл цохилох “зүрхтэй”, ажиллах “тархитай”, хөдлөх “мөчтэй” бүрэн бүтэн эд мөн буюу. Боловсролын ийм шинж чанарыг бид боловсролын супер тогтолцоо гэж үздэг. Тогтолцоо бүрдэхийн өөр нэг учир холбогдол бол түүнийг орчноос нь ялгаж сэтгэх явдал юм. Өөрөөр хэлбэл тухайн тогтолцоо хаанаас эхэлж хаана төгсөж буй тухай асуудал юм.

Боловсрол нээлттэй, чөлөөтэй, хувилбартай болохын хирээр хувь хүний олон талт хэрэгцээг хангах боломж улам бүр нэмэгдсээр байна. Хэрэв хүн албан боловсролоор сурах бололцоогүй бол албан бус боловсрол, зайн сургалт, амьдарч аж төрөх явцад олох анформал боловсролын аль Нэгэн хувилбарыг ашиглаж болно. Ийнхүү хувь хүний боловсролын хэрэгцээг дагаж боловсролын бүтцийн хувилбарууд үүсэж, тогтолцоо бий болох бүхэллэг шинж бүрддэг байна. Боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн болох албан ба албан бус, анформал боловсролын дотоод болон гадаад холбоо хамаарал, хөгжлийн зүй тогтлыг тогтолцооны шинжилгээний аргаар илүү тодорхой илэрхийлэн гаргах бололцоотой.

Түүхэн хөгжлийн үүднээс судалгаа явуулахад юуны өмнө үечлэлийг чухалчлан үзсэн байдаг. Монгол улсын боловсролын тогтолцооны хөгжлийг судлаачид янз бүр үечлэх боловч голцуу 1921 оноос хойш үеийг хамарсан нь Цөөнгүй. Тухайлбал Т.Машлай хувьсгалын өмнөх үеийн боловсролын систем (1911-1921), Ш.Бира, Л.Шагдарсүрэн нар хувьсгалын ардчилсан шатны үе (1921-1940), Д.Галсан Ардын хувьсгалын социалист шатны үе (1940-1970) гэх зэргээр боловсролын хөгжлийн түүхэн үеийг тодорхойлжээ. Харин судлаач Ш.Шагдар Монголын боловсролын хөгжлийн үечлэлийг Нэлээд өргөн хүрээгээр судалсан байна. Тэрээр Монголын боловсролын хөгжлийн түүхийг хоёр хэсэг, найман үе болгон хуваажээ. Эхний хэсэг нь “Монголд хүмүүжил гэгээрлийн ажил үүсэн хөгжсөн нь” гэх бөгөөд үүнийг дотор нь:

1. Эртний Монголын гэгээрэл хүмүүжлийн ажил (нэн эртнээс XIII зуун хүртэлх)
2. Их Монгол улсын ба түүний дараах үеийн гэгээрэл боловсролын ажил (XIII-XVII зуун)
3. Манжийн ноёрхлын үеийн Монголын сургууль гэгээрлийн ажил (XVII-1911 он)
4. Олноо өргөгдсөн Монгол улсын сургууль - Гэгээрлийн ажил (1912-1920 он)

5. Хоёрдугаар хэсэг нь “Орчин үеийн Монгол улсын гэгээрэл боловсролын ажил” гэх бөгөөд үүнийг дотор нь:
6. Сургууль гэгээрэл боловсролын байгууллага дахин байгуулагдаж хөгжин бэхэжсэн (1921-1940 он)
6. Бүх нийтийг анхан шатны боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн нь (1941-1957 он)
7. Бүх нийтийг бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн нь (1952-1926 он)
8. Өөрчлөн байгуулалт, ардчилсан шинэчлэлийн үеийн сургууль (1987 оноос хойш) гэжээ.

Боловсролын түүхэн хөгжлийг ийм маягаар үечлэхэд нийгмийн хөгжлийг формацийн онолоор тайлбарладаг баримтлалд тулгуурласан, улс төр, үзэл суртлын нөлөө чамгүй орсон байж мэдэх талтай. Харин ямар нийгэм, ямар үзэл санаа буйгаас үл шалтгаалан, боловсролын тогтолцооны өөрийнх нь технологи, жам ёсны шинж чанарт тулгуурлавал илүү нийтлэг байж магадгүй юм. Энэ нь боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн хөгжлийн явцыг харгалзан үечилнэ гэсэн үг. Тухайлбал:

- Амьдарч аж төрөх явцад олох боловсрол голлосон хөгжлийн үе
- Албан бус боловсрол голлосон хөгжлийн үе
- Албан боловсрол голлосон хөгжлийн үе
- Боловсролын тогтолцоо бүрэн утгаар бүрдсэн үе гэсэн маягтай байж болох мэт.

Тухайн онцлог байдлыг харгалзан, чухам аль үед боловсролын ямар дэд тогтолцоо түлхүү үүрэгтэй байсныг бодолцон, тодорхой нийгмийн боловсролын хөгжлийг үечлэхэд тогтолцооны онолыг баримталж болмоор санагдана. Боловсролын хөгжлийг ийнхүү тогтолцооны НБ хувьд үечлэх аргыг Монгол улсын боловсролын тогтолцоонд хэрэглэвэл дор дурдсан дүр зураг гарна. Үүнд:

1. Амьдарч аж төрөх явцад олох анформал боловсрол голлосон үе (нэн эртнээс XX зууны 20-иод он)

2. Албан бус боловсрол голлосон үе (ХХ зууны 20-иод оноос 50-иад оны дунд үе)
3. Албан боловсрол голлосон үе (ХХ зууны 50-иад оны дунд үеэс 90 -ээд оны дунд үе)
4. Боловсролын тогтолцоо бүрэн утгаар хэрэгжсэн эхэн үе (ХХ зууны 90 -ээд оны дунд үеэс хойш)


Боловсролыг тогтолцооны нь хувьд үечлэх явдал аливаа нийгэмд боловсрол, юуны тулд оршин Хөгждөгтэй холбоотой дотоод хүчин зүйлд үндэслэдэг бол түүхэн дарааллыг баримталсан үечлэл үйл явц, нийгмийн орчны мэт боловсрол юунаас шалтгаалж хөгждөг вэ гэсэн гадаад хүчин зүйлд тулгуурладаг зарчмын ялгаатай зүйл юм.

Боловсролыг дотоод хүчин зүйлд нь тулгуурлан үечлэхтэй холбогдуулан, шинжилж

үзвэл монгол улсад жам ёсны, үзэл сурталжсан, прагматик гэсэн хөгжлийн гурван янзын загвар байжээ гэж үзэж болохоор байна. Монгол улсын боловсролын

хөгжлийн эл гурван загварыг Нэгдүгээр зураг дээр тоймлон үзүүлэв.

Монголчууд соёл, боловсролын эртний өв уламжлалтай. Үр хүүхдээ сургаж ирсэн өөрийн арга хандлагатай, академик маягийн цэргийн болон иргэний боловсрол, түүнчлэн шашны боловсролын уламжлал бидэнд бий. Үл анзаарагдам хирнээ амьдарч аж төрөхийн үндэс байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицох арга хэрэгсэл болсон анформал боловсролын өвөрмөц хэлбэр нүүдэлч малчдын дунд оршсоор иржээ. Харин ХХ зуунд монгол улсын албан боловсролын хөгжилд үндсэн эргэлт гарсан. Өнгөрсөн зууны эхээр шударга ёс, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинэ давллагаа эхэлсэн байна. Монголын ард түмэн ч энэхүү тэмцэл, хөдөлгөөнд татагдан орж 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд тус улсад сэргэн мандлын шинэ эрин эхэлжээ. Энэ бол монгол улсад албан боловсрол давамгайлсан орчин цагийн боловсролын хөгжлийн эхэн үе байлаа.



Зураг 1. Монгол улсын боловсролын хөгжлийн загварууд

Монгол улсад боловсролын тогтолцооны анформал бүрэлдэхүүн эхэн үедээ өвөрмөц байдлаар давамгайлж ирсэн байна. Уяан дээр байгаа морио эмээллэж унаад, хонь буцаагаад ирж буй долоон настай хүүгийн тэрхэн зуур амжуулсан ажлыг өндөр боловсролтой гадаадын 20 настай залуу хөвүүн сурахын тулд ямар хэмжээний хүч, цаг зарцуулах вэ. Малчин хүүг юу ч сураагүй, ямар ч боловсролгүй хүн гэх үү. Хэрэв тэр хүү морь унаж чадахгүй, хонь эргүүлж мэдэхгүй бол нүүдэлч малчин гэдэг утгаар оршин амьдарч чадахгүй. Нүүдэлч малчдын амьдарч, аж төрөхийн утга учрыг боловсролын талаас нь сөхөн харахад сонирхолтой содон зүйл олон бий. Нүүдэлч малчны амьдрангаа суралцдаг өвөрмөц чанарыг боловсролын өнцгөөс харвал эрдэм судлалын сонирхолтой сэдэв юм. Нүүдэлч малчдын хүүхдийн амьдрангаа сурдаг арга хандлагаас өнөөгийн албан ёсны сургалтад ашиглах зүйл огт байхгүй гэвэл эндүүрэл болох болов уу. Өнөөгийн хүүхдүүд амьдралын цөөн цагийг сургалтын танхимд өнгөрөөж, дийлэнхийг гэр бүл, нийгмийн орчинд сургуулийн гадна өнгөрөөдөг. Үүнийг бодолцсон ч нүүдэлч малчны жам ёсны, эрчимтэй, авсаархан сургалтын арга хандлагыг олж ашиглаж чадвал багш бидний ажилд тус дэм болох нь дамжиггүй.

Нүүдэлч малчдын байгальтай зохицон аж төрдөг амьдралын арга зам сургалтын үр дүнд бүрэлдэж бий болдог гэсэн санаанд бид хүрээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, нүүдэлч малчид орчиндоо дасан зохицож амьдрахын үндэс нь сурахуй юм. Тэд сурсаар, дасан зохицсоор, сурсаар он цагийг туулж ирсэн бололтой. Амьд организм орчиндоо дасан зохицож байгалийн шалгарлыг даван туулж амьдардаг биологийн хууль бий. Энэхүү түгээмэл хууль нүүдэлч малчдад амьдарч аж төрөх явцдаа суралцах замаар олдог анформал боловсролоор дамжин хэрэгждэг байна. Энэ бүхэн монгол улсад боловсролын хөгжил эхлээд жам ёсны дагуу өөрийн ая тааваар явж ирснийг гэрчилнэ.

Гадаад орны туршлага, элдэв онол номлол, үзэл суртал, уламжлал зэрэг гадна орчноос үзүүлэх зориудын нөлөө багатай боловсролын жам ёсны загвар хүмүүний амьдрал, түүхийн урсгалд аандаа бүрэлдэн бий болжээ. Мэдээжийн хэрэг, энэ загварт амьдарч аж төрөх явцад олох анформал боловсрол голлоно. Түүний агуулгын гол үндсийг “монгол хар ухаан суулгах” гэсэн томъёоллоор илэрхийлж болох юм шиг санагдана. Ажил амьдралын дадлага туршлага, ур чадвар, мэдлэгийг хуримтлуулснаар хүүхдээ гүйлгүү монгол хар ухаан суулгахыг чухалчилж байлаа. Одон зурхай

зурах, хүн, мал эмчлэх, багаж зэвсэг хийх, бичиг үсэг заах мэт албан бус сургалтын зэрэгцээ ордны сургууль, бичээчийн сургууль, шавь сургууль мэт сургалтын хэлбэрүүд ч байв. Гүйлгүү монгол хар ухаан суулгах зорилго байсан ч түүнийг хүмүүн янз бүрээр эзэмшинэ. Харин хүн бүрд эрүүл чийр бие, саруул цэлмэг ухаан, хүнлэг сайхан сэтгэл хэрэгтэй гэж үзсээр иржээ. Бие, сэтгэл, ухаан хөгжүүлэх нь тухайн үеийн боловсрол агуулгын утга учир, мөн чанар болж байв. Тий. учраас орон зай, цаг хугацааны орчин буудал ч боловсролын агуулгын нийтлэг цөмд эрүүл саруул явж, сайн амьдарч, аж төрөх явдал голлож байлаа. Үүнд олон талын чадвар хамгаас чухал гэдгийг тайлбарлалтгүй. Ийм агуулгыг эзэмшсэнээр хүүхэд хүмүүн болж өсөн бойжоод насан туршдаа сурсаар, амьдарсаар, аж төрсөөр байх нь монгол боловсролын эл загварын мөн чанар юм. Боловсролын энэ загвар түүхэн дараалал бүхий зүйл биш харин түүхэн дарааллын явцад амьдралаар бий болсон үр дүн юм. Жам ёсны загварын агуулгад академик боловсрол багагүй хувийг эзэлж байсан бөгөөд түүнийг “эрдэм ном” гэсэн ухагдахуунаар илэрхийлдэг байлаа. Академик боловсрол цэргийн, иргэний, шашны хэлбэртэй байв. Харин академик боловсролыг хүүхдэд олгохдоо хатуу шалгуур тавьж “савыг үзэж сургах” онолын зарчмыг баримталдаг байжээ.

Монголчууд Евроазийн уудам нутаг дээр Их монгол улсаа байгуулан сүр хүчээ үзүүлж явсан үе байхад Манжийн эрхшээл дор дэлхийн хөгжлөөс хол бөглүү түгжигдмэл орчинд орсон зэрэг түүхэн хүчин зүйл боловсролын жам ёсны загварт зохих нөлөө үзүүлсэн нь мэдээж боловч уг загварын оршин ирсэн он цагийн машстабтай харьцуулахад тэр нь тухайн тухайн нэгэн зурвас үе байсан байж болох юм. Тухайлбал их сургууль хүртэл байгуулсан гэх яриа байдаг. Шашны боловсрол мэдэгдэхүйц хэмжээнд хүрсэн ч анформал боловсролтой харьцуулахад нийтийг хамарч чадаагүй, явцуу хүрээтэй байв.

Манай улсын боловсролын хөгжлийн дараагийн үед хэдийгээр анформал боловсрол урьдын адил байсан боловч албан бус боловсрол давамгайлах хандлагатай байв. Үндэсний ардчилсан хувьсгалын эхний жилүүдэд оюун санааны хоцрогдлыг даван туулах, шашны суртлаас ангижрах, бичиг үсэг тайлах, шинэ үеийн соёл түгээх зэрэг албан бус боловсролын ажил голлож байв. Үүнтэй холбогдуулан зөвхөн ганц баримт дурдахад “1946 онд улсын хэмжээгээр бичиг үсгийн орон тооны багш 339, орон тооны бус багш 3000 гаруй ажиллаж байв”.

“Залуучуудын эвлэлийн гишүүн бүр бичиг үл мэдэгч хоёроос доошгүй энгийн залуучуудыг шөфлэн авах ба улсын 25 жилийн баярын наана залуучуудын эвлэлийн бүх гишүүдийг шинэ бичигт тайлах үүргийг МХЗЭ-ийн Төв хороо авчээ.” Энэ баримтаас харахад бүх нийтээр нь бичиг үсэгт тайлах боловсрол гэгээрлийн нүсэр том ажлыг гүйцэтгэхэд олон нийтийн оролцоо, албан бус боловсрол хэрхэн давамгайлсан нь тодорхой байна. Түүнчлэн төв орон нутагт сургуулиуд байгуулагдаж нийтийг хамарсан албан боловсролын тогтолцооны үндсийг тавих ажлыг эхэлжээ. Хүүхдийг яс үндэс, эрэгтэй, Эмэгтэй, язгуур угсаа, шашин шүтлэг, хөрөнгө чинээний байдлаар ялгаварлахгүй, төлбөргүй сурах эрхээр хангаж хүн бүрд зориулсан боловсролын эхлэл тэр үед тавигдсан байна. Хэдийгээр албан ёсны сургууль ажиллаж байсан боловч тэдгээр нь нийгмийн амьдралд зонхилох нөлөө үзүүлж чадахааргүй цөөн байв. Харин 1921 оны хувьсгалын дараахнаас шинэ цагийн анхны бага сургууль байгуулагдан олширч, нийслэл хүрэнээс халин аймаг, хошуудад өргөжиж байлаа. Манай улс 1947 онд насанд хүрсэн бүх хүнийг бичиг үсэгт сургах зорилт тавьж анхдугаар таван жилийн эцэст (1948-1952) хүн амын үндсэн хэсэг бичиг үсэгт тайлагдсан байна. Ингээд 1956 оны байдлаар тус орны 13-45 насны хүмүүсийн 90,5 хувь бичиг үсгийн анхны МЭДЭГДЭхүүнтэй болсон байна. Түүх судлаач эрдэмтэд үүнийг бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилтын хамгийн гол асуудал нэгэнт шийдвэрлэгдсэнийг харуулав хэмээн дүгнэжээ. Ийнхүү тухайн үед ухамсарлагдахгүй, хүлээн зөвшөөрөгдөхгүй байсан ч албан бус боловсролын үр дүнд бичиг үсэгт тайлагдах талаар үндэсний хэмжээнд томоохон алхам хийсэн байдаг. Нийгмийн амьдралд гүйцэтгэсэн соён гэгээрүүлэх үүргийг нь харгалзан үзвэл албан бус боловсрол давамгайлсан гэх үндэс байгаа юм. Албан бус боловсрол давамгайлсан тэр үед бага, дунд сургуулиуд байгуулагдаж албан боловсролын институц хүчтэй бүрэлдэж бий болсон нь манай улсын боловсролын Хөгжлийн өнөөгийн амжилтын гол хөрс суурь бүрдэж байсан хэрэг юм. Албан боловсрол голлосон хөгжлийн гуравдугаар үед бүх хүүхдэд анхан шатны улмаар дунд боловсрол заавал олгох нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байна.

Сургуулийн насны бүх хүүхдэд анхан шатны боловсрол олгох ажил 1953/56 оны хичээлийн жилээс эхэлжээ. Энэ арга хэмжээнд хамруулан эхний 5 жилд бага сургууль 37, бүрэн ба бүрэн бус дунд сургууль 38 байгуулагджээ. Дараагийн таван жилд 8-12 насны бүх хүүхдийг сургуульд хамруулсан байна. Харин 1960 он гэхэд тус улсын 8-12 насны хүүхдийг нийтэд нь анхан шатны боловсролтой, Хот, аймгийн төвийн хүүхдийг 7 жилийн боловсролтой болгох асуудлыг шийдсэн байна. Манай улсад 1942 онд Монгол улсын их сургууль, 1951 онд Улсын багшийн дээд сургууль, жараад оноос техник мэргэжлийн сургуулиуд шинээр байгуулагдаж албан боловсролын бусад Дэд тогтолцоо бүрдсэн байна.

Хөгжлийн дээр дурдсан хоёр үед хамаарах боловсролын үзэл сурталжсан загвар хамгийн сайн судлагдсан, хамгийн тодорхой нь юм. “Бүх талын боловсролтой, өв тэгш” хүнийг сурган хүмүүжүүлэхэд боловсролын үйл ажиллагааг бүхэлд нь төвлөрүүлж, үзэл суртлын хатуу хяналт дор барьж байв. Гэсэн хэдий ч энэ үед тэрхүү “Нийгмийн хүн” бий болгох зорилтын үүднээс бүх хүүхдийг сургуульд хамруулах, анхан шатны болон бүрэн бус дунд боловсролтой болгох албан боловсролын тогтолцоог бүрэлдүүлж томоохон амжилтад хүрэхэд уг загвар чухал үүрэг гүйцэтгэсний ач холбогдлыг бууруулах аргагүй юм. Бүх нийтээр бичиг үсэгт тайлагдаж бага, дунд сургуулиуд байгуулах, багш бэлтгэх зэрэг дэс дараатай арга хэмжээ авч иргэний боловсролын шинэ тогтолцоо бүрдэх суурийг тавьсан байна. Тухайн загварын хувьд агуулгын МӨН чанар нь мэдлэг, чадвар, дадал олгоход, арга зүй нь албадмал шинжтэй байсныг өнөөдөр хүлээн зөвшөөрч байгаа.

Манай улс ардчилал, эрх чөлөөний үзэл санааг хүлээн авч зах зээлийн тогтолцоонд шилжих болсноор анформал боловсрол, албан бус боловсрол, албан боловсрол аль аль нь хүлээн зөвшөөрөгдөж зэрэгцэн орших боломж бүрдэж боловсролын тогтолцоо бүрэн агуулгаар бий болох нөхцөл бололцоо бий болсон байна. Энэ бол тус улсын боловсролын хөгжил шинэ үе шатанд орсныг гэрчилнэ. Монгол улсын түүхэн Дэвшлийн үе бүрд боловсролын хөгжилд үсрэлт маягийн өөрчлөлтүүд гарч түүний агуулга, бүтэц боловсронгуй болсоор иржээ. Дундад эртний үе, Их монгол улсын үед ч тийм өөрчлөлт гарсан байж болохыг түүхийн шинжлэх ухааны үүднээс судлууштай зүйл юм.

Боловсролын хөгжлийн шинэ шатанд түүнийг үзэл суртлаас чөлөөлж, онол арга зүйг нь шинэчлэн, олон хувилбараар хөгжих боломж бүрдүүлсэн байна. Албан бус боловсролыг хүлээн зөвшөөрч, өмчийн олон хэвшилд суурилсан боловсролын тогтолцоо бүрэн агуулгаар бүрэлдэж боловсролын үйлчилгээг нээлттэй чөлөөтэй, хүртээмжтэй үзүүлж эхэлжээ. Нийгмийн бусад салбарын адил боловсрол ч зах зээлийн өрсөлдөөн бүхий орчинд шилжиж прагматик маягийн загвар бүрэлдэж байна. Харин боловсрол дахь хар аяндаа гарч байгаа өрсөлдөөнд төр хэрхэн хандах, боловсролын хэрэгт хэрхэн оролцох явдал өнөө хир нь шийдлээ хүлээж буй тулгамдсан олон асуудлын зангилаа юм. Тулгамдсан асуудлыг урьдчилан харж шийдэхгүй зөнд нь орхих маягаар хандвал байдал улам хүндэрч болохыг амьдрал харуулсаар байгаа.

Улс орон боловсролын шинэчлэлдээ харгалзахыг ЮНЕСКО санал болгосон сурахуйн дөрвөн зорилго бий. Тухайлбал:

- Мэдэхийн тулд сурах (Learning to know)
- Хийж бүтээхийн тулд сурах (Learning to do)
- Оршихуйн тулд сурах (Learning to be)
- Хамтран аж төрөхийн тулд сурах (Learning to live together)
- Эдгээр нь хүмүүний сурахуйн нийтлэг зорилго болохыг харгалзан, манай улсын боловсролын өнөөгийн агуулгыг “ай” хэмээх хэсэгт ангилсан байдаг. Үүнийг багш нар заримдаа ЮНЕСКО-гийн дөрвөн “тү би” (to be) гэх болсон. Энэхүү дөрвөн “тү би” прагматик загварын агуулгын үндсийг бүрдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж, бүр цогц чадамж (competence) хэмээгдэх болжээ. Хэрэв үндэсний киррикулим, түүний нэгж, ээлжит хичээл бүрийг энэхүү философи маягийн хийсвэр зорилго руу шахвал албадмал Догматик хэлбэрийн хандлага гарч болзошгүй юм. Боловсролын шинэ стандарт
- Конструктивист онол хандлагад суурилах
- Мэдлэг зохиомжлон бүтээх аргазүйг ашиглах
- Судлагдахууны мэдлэгээс цогц чадамжидшилжих
- Багшийн хөгжлийг цогцолбор үзэх зэрэг үндсэн өөрчлөлт рүү хөтөлж буй учраас түүний ач холбогдол маргаангүй чухал юм. Гэхдээ шинэ загварын сургалтын агуулга хэт

онолдсон, хийсвэр шинжтэй, багшлахуй, сурахуйн практик үйл ажиллагаанаас хөндий, зах зээлийн үеийн хөгжлийн зүй тогтлыг нарийн тусгаж чадаагүй зэрэг учир дутагдал бий. Монгол улсын хөгжлийн прагматик загвар эдийн засгийн шилжилтийн хүнд нөхцөлд бүрэлдэн бий болох шатандаа яваа учраас түүний талаар тодорхой дүгнэлт гаргахад өнөөдөр эрт байна.

Дүгнэлт ба гаргалга

Нэг. Албан боловсрол (Formal Education), албан бус боловсрол (Non Formal Education), амьдарч аж төрөх явцад олох анформал боловсрол (In Formal Education) хоорондоо харилцан шүтэлцэж, нэгэн бүхэллэг чанарыг үүсгэн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.

Хоёр. Боловсролын хөгжлийг үечлэхдээ өөрийнх нь технологи, жам ёсны шинж чанарт тулгуурлавал илүү нийтлэг байж мэдэх учраас

- Амьдарч аж төрөх явцад олох боловсрол голлосон хөгжлийн үе
- Албан бус боловсрол голлосон хөгжлийн үе
- Албан боловсрол голлосон хөгжлийн үе
- Боловсролын тогтолцоо бүрэн утгаар бүрдсэн үе гэж боловсролын тогтолцооны бүрэлдэхүүний хөгжлийг харгалзан үечлэх боломж байна.

Гурав. Боловсролын хөгжлийг тогтолцооны нь хувьд үечлэх аргыг Монгол улсын боловсролын тогтолцоонд хэрэглэвэл:

1. Амьдарч аж төрөх явцад олох анформал боловсрол голлосон үе (нэн эртнээс XX зууны 20-иод он)
2. Албан бус боловсрол голлосон үе (XX зууны 20-иод оноос 50 -иод оны дунд үе)
3. Албан боловсрол голлосон үе (XX зууны 50-иод оны дунд үеэс 90 -ээд оны дунд үе)
4. Боловсролын тогтолцоо бүрэн утгаар хэрэгжсэн эхэн үе (XX зууны 90-ээд оны дунд үеэс хойш) байж болно.

Дөрөв. Боловсролыг дотоод хүчин зүйлд нь тулгуурлан үечлэхтэй холбогдуулан, Монгол улсад жам ёсны, үзэл сурталжсан, прагматик гэсэн хөгжлийн гурван янзын загвар байжээ гэж үзэж болохоор байна.

Тав. Нүүдэлч малчдын байгальтай зохицон аж төрдөг амьдралын арга зам, сургалтын үр дүнд бүрэлдэж бий болдог. Өөрөөр хэлбэл, нүүдэлч малчид орчиндоо дасан зохицож амьдрахын үндэс нь сурахуй юм. Амьд организм орчиндоо дасан зохицож байгалийн шалгарлыг даван туулж амьдардаг биологийн түгээмэл хууль нүүдэлч малчдад амьдарч аж төрөх явцдаа суралцах замаар олдог анформал боловсролоор дамжин хэрэгждэг байна.

Номзүй

1. Ш.Бира. БНМАУ-ын түүх соёл. түүх бичлэгийн асуудалд УБ. 1977.
2. Д.Галсан. БНМАУ-ын социалист хөгжлийн шатны (1940-75) сургуулийн боловсрол. Челябинск. 1977.
3. Жадамбаа Б. Шүтэн барилдахуй ба хүмүүний хөгжил -УБ.. 2007.
4. Г.Машлай 1911-1940 оны Монголын ерөнхий боловсролын сургуулийн хөгжилт. М. 1965.
5. Пүрэвдорж Ч. Боловсролын хөгжлийн онол арга зүйн асуудалд. УБ.1999.
6. Пүрэвдорж Ч Байгууллагын менежмент – УБ. 2006.
7. Л.Шагдарсүрэн БНМАУ-ын ерөнхий боловсрол хөдөлмөр политехник сургуулийн үүсэл. хөгжилт. УБ. 1976.
8. Тейлор Ф. Шинжлэх ухааны менежментийн зарчмууд. - Орос хэлнээс орч.. 2002.
9. Эрнальдо Дэ Сото. (The mystery of capital.) Капиталын нууц. Өрнөдийн ялгуулсан капитализм өөр газар өөдөлдгүйн учир. - Англи хэлнээс орч. Монсудар. УБ. 2004. www.broksatransword.co.uk.
10. Анохин П. К. Философские аспекты теории функциональных систем. -М: 1978.
11. Денисов А.А. Теоретические основы кибернетики .-Л. ЛПИ. 1975.
12. Друкер П.Ф. Задачи менеджмента в XXI веке. Пер. с англ. М. :Вильямс. 2000.
13. Мелентьев Л.А. Оптимизация развития и управление больших систем энергетики.- М.: Высш. школа. 1982.
14. Хакен Г. Синергетика. Иерархии неустойчивостей в самоорганизующихся системах и устройствах. Пер. с англ. -М. :Мир. 1985.
15. Cohen L., Manion L., Morrison K. (2007) Research Methods in Education(Sixth edition) Routledge Taylor &Francis Group. London and New York.
16. Daniel S. (2004) Management Strategy. School of Management North western University.